





## АГУУЛГА

хуудас

<b>1. Төслийн талаарх мэдээлэл, товч танилцуулга</b>	<b>2</b>
<b>2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт</b>	<b>3-6</b>
<b>3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт</b>	<b>7</b>
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8-9
3.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө, зорилт	10-11
3.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний	12
3.4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	13
3.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	14-16
3.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөны	17
3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18-21
3.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	22,23

**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

<b>Төслийн нэр:</b>	Төмөр бетон эдлэлийн үйлдвэрүүд
<b>Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:</b>	Байгууламж-Од ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011071150 Ригистрийн дугаар: 2745836
<b>Хаяг:</b>	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж өөрийн байр. Утас: 99040872 70001657

“Байгууламж Од” ХХК нь 2003 оноос хойш тасралтгүй Төмөрбетон эдлэлийн үйлдвэрийн чиглэлээрээ дагнан ажилллаж байна. Төмөр бетон эдлэлийн үйлдвэрийн үндсэн түүхий эд болох бетон зуурмагаа өөрийн бетон зуурмагийн үйлдвэрээс шууд нийлүүлдэг.

- Үйлдвэрийн үндсэн хэсгүүд:
- Арматур бэлтгэлийн хэсэг
- Хэв хашмал бэлтгэх хэсэг
- Дулааны боловсруулалтын хэсэг
- Бэлэн бүтээгдэхүүний агуулах
- Бетон зуурмагийн узель гэсэн үндсэн 6 хэсэгээс бүрдэнэ.

Төмөрбетон эдлэлийн үйлдвэр 1 буюу Дулааны сувгийн тэвш, таг зэрэг 13 нэр төрлийн жилд 12000-15000м<sup>3</sup>, Төмөрбетон эдлэлийн үйлдвэр 2 буюу Бохирын худгийн кольцоны үйлдвэр нь 9 нэр төрлийн 5000-6000м<sup>3</sup> бетон эдлэл үйлдвэрлэнэ.

Төслийн байршил: Манай байгууллагын үйлдвэрүүд Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. “Байгууламж-Од ХХК Нийслэлийн Засаг даргын 2015 оны 08 сарын 27-ны өдрийн А/701 тоот шийдвэрээр 1681600380 дугаар бүхий /2019онд шинэчлэгдсэн/ 10679м<sup>2</sup> талбайтай нэгж талбарыг 10 жилийн хугацаатай, Мөн Нийслэлийн Засаг даргын 2015 оны 07 сарын 06-ны өдрийн А/596 тоот шийдвэрээр 1681900875 дугаар бүхий /2021онд шинэчлэгдсэн/ 10545м<sup>2</sup> талбайтай нэгж талбарыг 5 жилийн хугацаатай тус тус үйлдвэрийн зориулалтаар эзэмшүүлсэн байна.

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1. Гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь үйлдвэрийн үндсэн түүхий эдүүд болох элс хайрга болон цемент хүлээн авах үед үүсэх тархалт, элс хайрганы хадгалалт, үйлдвэрлүү ковшоор зөөхөд үүсэн тоосжилт, үйлдвэрийн орчимд автомашинаас ялгарах агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр бий болох, автомашины тос, тослогооны материал хаягдах, хөрсийг автомашины тос тослох материалууд, химийн нэмэлт бодис, технологийн угаалгын ус-хаягдлаар бохирдуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэж буй гүний худгийн усыг зохисгүй хэрэглэснээс гүний нөөцөд нөлөөлөх зэрэг болно.

Дээрх үүсч буй сөрөг нөлөөллүүд нь төслийн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа болно. Хүснэгт 7-д голлох сөрөг нөлөөллийг үйлдвэрийн үйл ажиллагаа болон байршилтай холбогдуулан голлох сөрөг нөлөөллийг схемчлэн харуулав.

#### Голлох сөрөг нөлөөллийн чанарын үнэлгээний шалгуур

Хүснэгт 1

Төвшин	Зэрэг	Тайлбар		
		Сөрөг нөлөөлөл	Хөрөнгө	Шийдэл
V	Их	Түүхий эд буулгах үед болон хадгалалт, үйлдвэрлүү зөөж тээвэрлэх үед үйлдвэрийн талбайгаас үүсэх тоосжилт	Дунд зэргийн хохирол	- зам талбайн усалгаа, - түүхий эдийн талбайн хаалт хийх
III	Дунд	химийн нэмэлт бодис, автомашины болон үйлдвэрийн тос тослогооны бодисын тархалт	их хохирол	- Үйлдвэрийн удилдлага болон мэргэжлийн байгууллагын шийдэл
V	Их	бохирдсон хөрс болон усаар дамжин гүний ус бохирдох	Их хохирол	- бохирдол үүсэхээс ямагт сэргийлж ажиллах шаардлагатай зам талбайг хатуу хучилттай болгох
III	Дунд	Дуу чимээ, доргионы бохирдол	хүний эрүүл мэнд	- Үйлдвэрийн шийдэл



## Магадлалын үнэлгээний шалгуур

Хүснэгт 2

Төвшин	Зэрэг	Тайлбар
I	бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	магад болохгүй	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй байж болзошгүй (50-70%)
V	лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)



## Эрсдлийн чанарын үнэлгээний матриц

Хүснэгт 3

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

## Эрсдлийн чанарын тайлбар

Хүснэгт 4

Эрсдлийн төвшин	Удирдлага
L бага эрсдэл	ердийн үйл ажиллагааны журмаар зохицуулах
M дунд эрсдэл	байгууллагын удирдлага хариуцах ба хариуцлага нь тодорхой байх шаардлагатай
H их эрсдэл	байгууллагын дээд удирдлага, орон нутгийн захиргаа, хяналтын байгуулагаас анхаарах шаардлагатай.
E гамшгийн эрсдэл	байгууллагын дээд удирдлага, улсын мэргэжлийн хяналт, онцгой байдлын байгуулагаас анхаарч, онцгой арга хэмжээ авах шаардлагатай

Мөн түүнчлэн “Байгууламж-Од” ХХК-ийн бетон эдлэлийн үйлдвэрүүдийн төслийн голлох сөрөг нөлөөллүүдийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр ялган ангилж харуулав.

## 2.2. Болшзошгүй сөрөг нөлөөлөл

Тухайн төсөл хэрэгжих явцад байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон гол нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг. Энэ арга нь үйл ажиллагаа явуулах үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг бөгөөд хэрэв нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэдэг.

Дээрх үйл ажиллагаанаас Байгаль орчны төлөв байдал, экологи, орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэж доорх хүснэгтээр үзүүлэв.



**Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь  
нөлөөллийн төрөлтэй уялдах байдал**

Хүснэгт 5

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			үргэлжлэх хугацаа				Эрчим		
	шууд	шүүд бус	өөрөө зохицуулагдах	урт хугацааны	богино	буцаж	буцалтгүй нөлөөлөх	хүчтэй	дунд зэрэг	бага зэрэг
<b>1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал</b>										
Хөрсний элэгдэл, эвдрэл			X		X					
Хөрс, ургамлын талхагдал		X			X					X
Агаарын орчинд нөлөөлөх	X				X					X
<b>2. Төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудал</b>										
Шатах, тос, тослох материалууд хөрсөнд үзүүлэх нөлөө			X	X						X
Машин механизмын үйлчлэлээр байгаль орчин нөлөөлөх нөлөөлөл	X			X						X
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсгэх дуу шуугианы нөлөө	X				X					X
Агаарын бохирдолтонд үзүүлэх нөлөө	X				X					X
Химийн бодисын тархалт үүсэх		X			X					X
<b>3. Байгаль орчны өөрчлөлт</b>										
Хөрсний элэгдэл, бохирдол			X		X					X
Агаарын бохирдол		X				X				X
<b>4. Нийгэм эдийн засгийн асуудал</b>										
Хувийн өмчийн болон татварын орлого нэмэгдэх	X			X						X
Орон нутгийн орлого нэмэгдэх	X			X						X
Ажлын байр нэмэгдэх	X			X						X
<b>6. Бусад асуудал</b>										
Хөрсөнд үзүүлэх туслах материалын нөлөө		X			X					X
Чимээ шуугианы нөлөө		X			X					X
Болгоомжгүйгээс гал түймэр гарах		X					X	X		
Хүчтэй буюу аадар борооны улмаас үер болох	X				X				X	
Хатуу, шингэн хог хаягдал ихсэх	X			X						X
<b>Дүн</b>	16	2	-	5	12	-	2	5	11	2

**Тайлбар:** х-болзошгүй нөлөөлөл, бөглөгдөөгүй нь тухайн төсөлд хамааралгүй.



**ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ****Төмөр бетон эдлэлийн үйлдвэрүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь:**

Үйл ажиллагаагаа явуулахдаа байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- БОМТ-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болсон байна.
- Ажиллагсад нэг бүр байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд үүргээ биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалтанд хамрагдсан ур чадвартай мэргэжилтэнтэй болсон
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг урьдчилсан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалж, хамгаалах
- Баянгол дүүргийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллана.
- Байгаль орчин хамгаалах сөрөг нөлөөллийг багасгах талаар ажиллагсдад зааварчилгаа өгч гарын авлага материалаар хангах
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх



## 3.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6

№	Гол болон болшошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх авто машин, механизмын техникийн хэвийн ажиллагааг болон шатах тослох материалын зохистой хэрэглээг хангах	Тээвэрлэлт үйчилгээнд хэрэглэж буй тээврийн хэрэгсэл	ш	200 000	7	1 400 000	Цаг тухайд нь техникийн үйлчилгээ хийх нь агаарын бохирдлыг бууруулна 3 ба 9 саруудад Давтамж нь 2 удаа	MNS5013520038 MNS5014:2003
		Агаарын мониторинг хийх	Төсөл хэрэгжүүлж буй гадаад орчин	ш	56000	2	112000	Жилд 2 удаа	MNS4585:2016
		Үйлдвэр 1-дээр Орчны тоосжилтыг дарах усан чийгшүүлэгчийг тогтмол хийх	Үйлдвэрийн хашаан дотор	м2	25 000	42	1 050 000	6-9 сар хооронд	-
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	Төслийн хүрээнд	ш	100 000	1	100 000	7 сард	Усны тухай хуулийн 12.1.4 заалт, БОНХАЖ-ын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015оны А-30/127тоот хамтарсан тушаалаар батлагдсан УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН ЭРҮҮЛ АХУЙН БҮСИЙН ДЭГЛЭМИЙН МӨРДӨХ ЖУРАМ-ын 3.9 дэх заалт
		Ус ашиглах гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	ш	х	х	х	х	
		Усны мониторинг	Худаг	ш	162 000	2	340000	Жилд 1 удаа	



3	<b>Хөрсөн бүрхэвч</b>	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд /шугам, хоолой/ тогтмол хяналт хийж, цэвэршүүлсэн усанд шинжилгээ хийлгэж байх	Үйлдвэрийн талбай	ш	100 000	2	200 000	Жилд 1 удаа	MNS4585:2016	
		Хөрсний мониторинг	Үйлдвэрийн талбай	ш	56000	2	112000		MNS5850:2008	
<b>Нийт дүн</b>							<b>3 314 000</b>			




### 3.2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн зам талбай ихэнх хэсэг нь хатуу хучилттай боловч ногоон байгууламж багатай байна. Энэ нь тухайн орчинд ихээхэн тоосжилт үүсдэг.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг үйлдвэрийн дотоод тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах, бут зүлэгжүүлэх арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм. Талбайн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан нөхөн сэргээх болон ургамалжуулах ажлыг жил бүр хийх шаардлагатай.

Газрын тохижилт цэцэрлэгжүүлэлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм.



#### Төмөрбетон эдлэлийн үйлдвэрүүдийн төлөвлөлт



## 3.2.1 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ЗОРИЛТ

Хүснэгт 7

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжмх нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
1	БОННУ гээр зөвлөсөн ажлыг хийх мөн Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу журмыг хэрэгжүүлэх	Үйлдвэр 1-ийн талбайд тарисан зүлэгэнд арчилгаа дахин сэргээлт хийх	Хашааны дотор гадна	М <sup>2</sup>	500	6000	3 000 000	6 сард Жил бүр	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль 7.2.4
2	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу журмыг хэрэгжүүлэх	Үйлдвэр 1-ийн талбайд зүлэг тарих	Хашааны дотор	М <sup>2</sup>	74	33000	2 442 000	4-8 сард	
3	Орчныг цэвэр байлгах талаар хороотой хамтран ажиллах	Эзэмшил газрын ойр орчмыг хогыг цэвэрлэх	Хашааны гадна авто зам, замын хөвөө	М <sup>2</sup>	350	430	150 500	8 сард	
<b>Нийт дүн</b>							<b>5 592 500</b>		

Жил бүр мод зүлэг тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болж арчилгааг хуваарийн дагуу гүйцэтгэнэ



### 3.3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны ямны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.



## 3.4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд аюулгүй ажиллагааг чанга мөрдөх зайлшгүй шаардлагатай бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг мөрдөн ажилладаг. Төсөл хэрэгжүүлэгч нь ажилтны эрүүл аюулгүй ажиллаж хөдөлмөрлөх орчин болон ажлын байрыг бэлтгэх үүргийг хүлээдэг тул ХАБЭА-н тухай хуулийн шаардлагуудыг хангаж төслийг үргэлжлүүлнэ. Бид аюулгүй ажиллагааг хангах, ямар нэгэн эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг төлөвлөгөөт болон тухайн үеийн эрсдэлийн үнэлгээг хийж ажилладаг. 2020 онд хэрэгжүүлэх ажлуудыг тусгаж өглөө.

Хүснэгт 8


№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	нийт зардал /Т/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам стандарт
1	Өргөн тээвэрлэх машин механизмын эвдрэл гэмтэл	Өргөн тээвэрлэх кран, тайлыг магадлалаар оруулах	Үйлдвэрийн кранууд	10	150 000	1 500 000	Жилд нэг удаа 9 сард	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй тухай хууль 2008.5 сар
2	Гал түймэр	гал унтраах хуурай хорыг шинэчлэх хуучин хорнуудад үзлэг үйлчилгээ хийх,	Үйлдэрийн цех	15	1 000 000	1 000 000	Тухай бүрт	
3	Үйлдвэрлэлийн осол гэмтэл, бэртэл	Нийт ажилчдын сургалт зохион байгуулах	Төслийн ажилчид	120	10 000	1 400 000	Жил бүр 3 сард	
4	Мэргэжилээс шалтгаалах өвчлөл	Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг	Төслийн шинэ ажилчдад	16	70000	1 120 000	Жил бүр 2 ба 3 сард	
<b>Нийт дүн</b>						<b>5 020 000</b>		



### 3.5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас түүхий эд хураах талбайн орчимд хайрга, дайрга тархаж хаягдаж болох тул тэдгээрийг тараахгүй байх арга хэмжээ авах хэрэгтэй. Химийн нэмэлт бодисын сав баглаа боодлыг нийлүүлэгч байгууллагад буцаан тушаадаг. Харин тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний явцад ашиглалтаас бүрмөсөн гарсан мотор, сэлбэг хэрэгсэл зэрэг зүйлс гарах бөгөөд эдгээрийг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгүүдэд тушаах шаардлагатай.

Үйлдвэрийн ажиллагсадын ахуйн болон цайны газрын хоол хүнсний зүйлийн үлдэгдэл, баглаа боодол зэрэг хатуу хог хаягдал гарна. Хог хаягдлыг лонх, лааз, цаас, хоолны үлдэгдэл, бусад гэсэн байдлаар нь ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэгт төвлөрүүлэн гэрээгээр зохих журмын дагуу зайлуулах нь зүйтэй. Ийнхүү хог хаягдлын төлөвлөгөөг гаргахдаа тус үйлдвэрийн бүхий л үйл ажиллагааны явцад гарч байгаа хог хаягдлын судалгааны үндсэн дээр боловсруулав.



Хог хаягдлын ангилал, хэмжээ



**ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ЗАРДАЛ**

Хүснэгт 9

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам стандарт
Ахуйн	Тусгайлан бэлтгэсэн хогийн саванд хадгалах, хогын цэгт хаях	Төслийн тайлбай	ш	100 000	6	600 000	сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль, хаягдлыг ангилан ялгаж хаях журам
Үйлдвэрийн	Тусгайлан бэлтгэсэн хогийн саванд хадгалах хогын цэгд хаях	Төслийн тайлбай	ш	100 000	6	600 000	сард 1 удаа	
Аюултай	х	х	х	х	х	х	х	х
						<b>1 200 000</b>		



### 3.6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗАРДАЛ

Хүснэгт 10

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлжх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2022 он				
		сар	сар	сар		
БОМТ-нд тусгагдсан ажлын дэлгэрэнгүй төсөвийг гаргаж дотооддоо батлах	-	3	-	-	Ц.Булгантамир	
Ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн ажлын мэргэжлийн байгууллагатай хамтран хийх	-	5	6	-	Ц.Булгантамир	
Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх	400 000	5	-	-	Ц.Булгантамир	
Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, ангилах, Хог хаягдлын хор хөнөөлийн таниулах лекц явуулах	400 000	5	-	-	Ц.Булгантамир	
<b>НИЙТ ДҮН</b>	<b>800 000</b>					



### 3.7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “**орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**” гэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгасан байх болно. Үүнд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл;
- Хяналт-шинжилгээ явуулах зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд;
- Хяналт-шинжилгээ явуулах төрөл, хэлбэр;
- Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил;
- Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, давтамж;
- Хяналт-шинжилгээ явуулах арга, аргачлал;
- Хяналт-шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Ийнхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа 2011 оны 2-р сарын 16-ны өдрийн БОАЖЯ-ны сайдын №А-36 тоот тушаал “Журам шинэчлэн батлах тухай /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам/-ыг удирдлага болгон ашиглав.

Орчны хяналт шинжилгээний дүнгүүдийг өмнөх дүнгүүдтэй харьцуулж өөрчлөлтийг хянах бөгөөд байж болох дээд хязгаар нь стандарт байна.

- НЭГ. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
  - Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл
  - Төслийн талбайн хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл
    - Хяналт - шинжилгээ явуулах үзүүлэлт:
  - Cd, Cr, Hg, Br, Pb, Zn, Cu, Co, Sr, Rb, Zr зэрэг хүнд металлын бохирдлын төвшнийг тодорхойлуулах
    - Байршил
  - Бетон зуурмагийн узель, хог хаягдлын цэгийн орчмын цэг
    - Хийх ажлын дараалал
  - Хөрсний зүсэлт хийх (0.5-1.0 м гүн).
  - Орчин, хөрсний гадарга, хөрсний зүсэлтийн фото зураг авна.
  - Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэл хийнэ
  - Дээж авалт (дээж тус бүр гүн, өнгө, ... солбицол бичсэн хаягтай байна)
  - Итгэмжлэгдсэн лабораторит хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.
    - Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, график
  - Жилд 2 удаа
    - Хэрэглэгдэх багаж төхөөрөмж
  - Зүсэлт хийх хүрз
  - Хөрс дээжлэгч уут, сав
  - Фото аппарат



- Аргачлал
- MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
- MNS 3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
- MNS 3298-1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
- MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
  - Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ
- Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008.
- ХОЁР. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
- 2.1. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл
- Хэрэглээгээс гарсан цэвэршүүлсэн бохир ус
- Гүний худаг
- 2.2. Хяналт-шинжилгээ явуулах үзүүлэлт
- Худгийн усанд
- Усны чанарын үндсэн үзүүлэлт, Био идэвхит нэгдлүүд
- Цэвэршүүлсэн бохир усанд
- Цэвэршүүлсэн бохир усан дахь бохирдуулах бодисын агууламж ба бусад үзүүлэлт
- 2.3. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр
- Сорьц авч шинжилгээ хийлгэх
- 2.4. Байршил
- Бохирын сан
- Гүний худаг
- 2.5. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж
- Дээжлэгч болон цэвэрхэн усны шил, сав
- 2.6. Хийх ажлын дараалал
- Усны дээж авах саваа бэлтгэнэ, сайтар цэвэрлэсэн байна.
- Дээж авах гэж буй усаар сав болон бөглөөг 2-3 удаа зайлна.
- Дээж авалт (дээж тус бүр хаягтай байна).
- Итгэмжлэгдсэн лабораторит хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.
- 2.7. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа график
- Жилд 2 удаа
- 2.8. Аргачлал
- MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх
- MNS 5667-10:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах
- MNS 5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга
- MNS 4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
- MNS (ISO) 5667-6:2001 Усны чанар Дээж авах-6-р бүлэг Гүний уснаас дээж авах
- 2.9. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ
- Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018
- Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 6148:2010
- “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2011



- ГУРАВ. АГААР ОРЧНЫ БОХИРДОЛ
- 3.1. Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй үзүүлэлтүүд:
- Агаар дахь NO<sub>2</sub>, SO<sub>2</sub>-ийн агууламж, тоос PM10, PM2.5, дуу чимээ
  - Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр:
- Сорьц авах (агаар, тоос,)
- Хэмжилт хийх (NO<sub>2</sub>, SO<sub>2</sub>, тоосжилт, дуу шуугиан)
  - Байршил
- Түүхий эд хадгалах талбай орчимд
  - Хийх ажлын дараалал:
- Тогтоосон хугацаанд сонгосон цэгт багажийг байрлуулна.
- Орчны бичиглэл хийнэ. Цаг агаарын төлөв байдлын талаар орчны бичиглэл хийнэ.
- Хэмжилт хийх үеийн агаар, хөрсний температур, салхины хурд, чиглэл, агаарын харьцангуй чийг зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж тэмдэглэл хөтөлнө.
- Зориулалтын автомат багажны тусламжтайгаар хэмжилтийг гүйцэтгэнэ.
  - Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж:
- Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээг жилд 2 удаа
  - Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал:
- MNS 5003:2000. Чимээ шуугианы-Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй. Чимээ шуугианыг хэмжих
- MNS 0017-5.1.21:92. Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ, дуу чимээний хүлцэх түвшин, хэмжих арга
- MNS 0012-013:1991. Ажлын байрын агаар. Ажлын байрны агаарын бүс
- Бусад хамаарах аргачлал
  - Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ:
- MNS 0012-013:91. Ажлын бүсийн агаар. Эрүүл ахуйн шаардлага
- Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4585 :2007
- Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5885 : 2008
- MNS 5002:2000. Чимээ шуугиан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр. Чимээ шуугианы хэм хэмжээ болон аюулгүй байдлын ерөнхий шаардлага
- MNS 4990:2000. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага



## 3.7.1 ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

“Байгууламж-Од” ХХК-ийн Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Төмөр бетон эдлэлийн үйлдвэрүүд” төслийг хэрэгжүүлэхэд дээрх аргачлалын дагуу “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийг явуулах үүрэгтэй бөгөөд гаргах зардлыг тус байгууллага нь бүрэн хариуцна.

Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ-н харьяа БОХЗЛ, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Монгол ус ТӨҮГ-ын усны лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

Хүснэгт 11

	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	БГД-ийн 20-р хороо БҮК ард ҮЙЛДВЭР-1 ТЭЦ-4 ийн зүүн талд ҮЙЛДВЭР-2  Жилд 2 хавар намар, 3 ба 10 сар		2 удаа	56000	112 000		MNS <b>5850:2008</b>
2	Хөрсний агрохимийн найрлага				56000	112 000		
3	Хөрсөн дэх пестицидийн гербицидийн үлдэгдэл				52000	104 000		
	НИЙТ					<b>328 000</b>		



### 3.8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12

№	БОМТ,БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	БГД-ийн 20-р хорооны ИХТөлөөлөгч нар Байгууламж-Од ХХК-н удирдлагууд	Цаасан тайлан	Төслийн БОННУ-ний дагуу хийсэн ажлуудыг танилцуулах	10 сард	150 000	БОМ Ц.Булгантамир	Байгууламж-Од ХХК оффис
					<b>150 000</b>		



## 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 13

Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ, мян.төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3 314 000
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	5 592 500
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	---
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5 020 000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1 200 000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, зардал	800 000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	328 000
Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	150 000
<b>Нийт</b>	<b>16 269 500</b>